Төсөл хэрэгжих талбай болох Төв аймгийн Сэргэлэн сум нь Улаанбаатар хотоос 62 км, Төв аймгийн төв Зуунмод хотоос 18км зайд байрладаг. Уур амьсгалын үндсэн тодорхойлолтыг мэдээллийг Зуунмод станцаар сүүлийн 4 жилийн суурь мэдээллээр нэгтгэн боловсруулсан. Зуунмод суманд агаарын дундаж температур хүйтний улиралд -14-20 градус хүйтэн, дулааны саруудад агаарын дундаж температур 15-18 градус дулаан байдаг. Өвөлдөө агаарын үнэмлэхүй температур -39 градус хүрч хүйтэрдэг, харин зундаа 36 градус хүрч халдаг байна. Орох хур тунадасны хэмжээ нь өвлийн саруудад 2.4-12.1 мм цас, зуны улиралд 128.7-249.6 мм бороо ордог.

2.2 Геологийн тогтоц ба геоморфологи


Далайн түвшнээс дээш дунджаар 1200-1500 м өргөгдсөн. Хэнтийн нуруу, Заамарын нуруу, Зоргол хайрхан, Хустайн нуруу зэрэг уулархаг гадаргуутай. Асралт хайрхан (2800 м), Богд хан, Батхаан зэрэг уулс бий. Нутаг дэвсгэрийн 16.4 хувийг ой мод, 36.5 хувийг хээрийн бүс эзэлдэг. Газар зүйн байршлаар Хангай, Хэнтийн уулархаг, Дорно Монголын талархаг мужид багтана. Нутгийн хойд хэсгийн уулын өргөн хөндийнүүд нь газар тариаланд тохиромжтой хүрэн бор хөрстэй, өмнөд хэсэг нь гүвээ толгод бүхий тал хээр газар юм.

ГИДРОГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ: 2003-2006 онуудад хийгдсэн нийслэлийн геоэкологийн судалгааны ажлын тайлангаас авлаа. Судалгаанд хамрагдсан дэвсгэр талбайн хэмжээнд тухайн бүс нутгийн шинж төрхтэй гидрогеологийн нөхцлийг илэрхийлж буй газрын доорхи усны тархалт, бүрэлдэн тогтолтын байгалийн ерөнхий зүй тогтол болон геологийн тогтоцын суурь нөхцлийн өвөрмөц онцлогийг үндэслэн, гидрогеологийн давхрага зүйчлэлийн хувьд дараахи уст үе давхарга, цогцолбор, газрын доорхи усны бусад хуримтлал, бөөгнөрөлийг ялгаж байна. Үүнд:

Аллювийн гарал үүсэлтэй орчин үеийн сэвсгэр хурдасны уст үе давхарга (alQ2)
Делюви–пролювийн гарал үүсэлтэй дээд плейстоцен–орчин үеийн сэвсгэр хурдасны уст үе давхарга (dpQ1-2)
Доод цэрдийн настай тунамал хурдасны уст үе давхарга (K1)
Дээд триас–доод юрын настай гүний шургамал чулуулгийн массив дахь алаг цоог тархалттай газрын доорхи ус (T3–J1)
Доод–дунд карбоны настай тунамал–хувирмал чулуулгийн зузаалаг дахь уст цогцолбор(C1-2)
Доод–дунд девоны настай тунамал–бялхмал–хувирмал чулуулгийн зузаалаг дахь алаг цоог тархалттай газрын доорхи ус (D 1-2)

2.2.1 Төслийн талбайн газар чичирхийллийн хэмжээ


Монгол орны газар хөдлөлийн идэвхжилт нь Евро-Азийн болон Энэтхэгийн хойгийн шахалтын бүсэд оршдогтой холбоотой юм. Монголд газар хөдлөлтийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлах судалгаа 1957 онд анхны газар хөдлөлтийг бүртгэх “Улаанбаатар станц” байгуулагдсанаар эхэлсэн түүхтэй. Монгол орны нутаг дэвсгэр нь Төв Азийн газар хөдлөлийн идэвхтэй бүсэд оршдог болохыг багажийн судалгаанаас хойшхи 50 гаруй жил хийсэн эрдэм шинжилгээний ажлын үр дүн нотолсон. Өнгөрсөн зуунд Монгол оронд магнитуд нь 7 ба түүнээс дээш 30 гаруй газар хөдлөлт болсны дөрөв нь 8 ба түүнээс дээш магнитудтай болсон ба энэ нь тус бүс нутаг газар хөдлөлийн идэвхтэй бүс болохыг батлан харуулдаг. Монгол орны нутаг дэвсгэрт явуулсан тектоник, геологи, газар хөдлөлийн түүхэн болон багажийн судалгаа, хүчтэй газар хөдлөлийн голомтын бүсэд хийсэн сейсмогеологийн судалгааны үр дүнг нэгтгэн “Монголын нутаг дэвсгэрийн ерөнхий мужлалын зураг” (М1:2500000, 1983)-аар нийт нутаг дэвсгэрийн 75% хувь нь VII ба түүнээс дээш баллын газар хөдлөлт болох магадлалтай бүсэд оршиж байна. Энэхүү VII баллын бүсэд Улаанбаатар хотын нутаг дэвсгэр мөн багтаж байна [1].



Зураг 6 Газар чичирхийллийн хэмжээ

2.3 Гадаргын ус

Туул гол нь эхэндээ (эхээс 170 орчим км) олон тооны гол горхи, булаг ихтэй бөгөөд Хэнтийн нурууны салбар уулсаас эх авсан Галттай, Хийд, Хаг, Зүүн баян, Тэрэлж, Улиастай, Сэлбэ зэрэг голууд цутгах ба харин голын уртын дагуугийн үлдэх ихэнхи доод хэсэгт Түргэн, Харбух, Тосон зэрэг цөөн тооны жижиг гол горхиуд цутгана. Голын ус хурах талбай 49900 км², урт нь 874 км, ус хагалбарын шугамын урт 2055,6 км, ус хурах талбайн дундаж өндөр 1474 м, голдрилилын ерөнхий хэвгий 13% юм. Туул голын савд гол, горхины сүлжээний нягтшил дунджаар 0.39 км/км², хэсэглэн авч үзвэл голын эх Гачуурт хүртэл 0.54 км/км², Гачууртаас Лүн 0.1 км/км², Лүнгээс Заамарын алтны бүс Орхон Туулын бэлчир хүртэл 0.05 км/км² байна. Туул голын өргөн нь үергүй үед 35-75 м, гүн нь 0.8-3.5 м, урсгалын хурд 0,50-1.50 м/с, эргийн өндөр 0,5-2,5 м байдаг./Эх сурвалж: Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Усны нэгдсэн менежмент, Туул голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулахад зориулсан судалгааны эмхэтгэл, УБ, 2012/ Туул голын ус хэмжилтийн Улаанбаатар харуулын урсацын ажиглалтын мэдээнд (1945- 2008) тулгуурлан жил бүрийн зарцуулгаар Туул голын тэжээлийг тогтоох урсацын гидрографын задлан ялгалт хийсэн дүнгээс үзвэл олон жилийн дунджаар хайлсан цас, мөсний ус 10.2%-ийг, газар доорх ус хөрсний усны тэжээл 17.65%, хур борооны ус 72.15% тус тус эзэлж байна.



Зураг 7. Төслийн талбайн туул голын усны сав газарт хамаарна.

2.4 Хөрсөн бүрхэвч

Төв аймаг, Сэргэлэн сум нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалын Хар хүрэн, хүрэн хөрсний дэд бүсийн Мааньтын тойрогт багтана. (МУ-ын Үндэсний Атлас, 2009). Улаанбаатар хотоос 62 км, Төв аймгийн төв Зуунмод хотоос 18 км зайд байрладаг.

2.5 Ургамлан бүрхэвч

Монгол-Дагуурын уулын ойт хээрийн тойрогт Хэнтийн нурууны захын салбар уулсыг хамрах бөгөөд Хэнтийн тойргийг тал цагираг байдлаар хүрээлэн оршино. Хэнтийн нурууг тойрсон Онон, Улз, Туул, Хараа, Ерөөгийн хөндийн зурвас нутгийг хамаарна. Ургамлын аймгийн хувьд гол нь Дагуурын ойн ба уулын хээрийн төлөөлөгчдөөс, өмнөд захаар нь Монголын хээрийн төлөөлөгчдөөс бүрдэл бүхий уулархаг хээрийн ургамал зонхилно. Тус тойрогт нийт 1307 зүйл тархсан ба зөвхөн энэ тойрогт тохиолдох 50 зүйл ургамал ургана.

2.6 Амьтны аймаг

Судалгааны талбай орчмын нутаг нь монгол орны амьтны аймгийн газар зүйн мужлалаар (Банников, 1954) Хэнтийн тойрогт багтана. Хэнтийн тайгын голлох элемент болох олон зүйлийн хөхтөн амьтдын тархалттай. Хан Хэнтийн дархлагдсан нутгийн хүрээнд 15 овог, 27 төрөлд хамаарах 50 гаруй хөхтөн, суурин болон нүүдлийн 250 гаруй зүйлийн жигүүртэн шувуу, 3 зүйл могой, 1 зүйл бах, 1 зүйл гүрвэл болон 9 зүйл загас тэмдэглэгдсэн байдаг.

Хөхтөн. Хөхтөн амьтдыг тархалтаар нь ойт хээрийн, ойн, таг цармын гэж 3 дэд бүслүүрт хувааж үздэг. Тус тойргийн амьтны аймгийн хөхтөн амьтдын зүйлийн бүрдлийг нь гаргавал: Дагуур зараа- *Erinaceus dauricus* Дагуур огодой – *Ochotona daurica* Асганы огодой -*Ochotona hyperborea* Тарвага– *Marmota sibirica* Урт сүүлт зурам-*Citellus undulatus* Үлийн цагаан оготно- *Lasiopodomys brandti* Монгол чичүүл- *Meriones unguiculatus* Сибир алагдаага- *Allactaga sibirica* Мануул- *Felis manul* Хярс- *Vulpes corsac* Хотны үен- *Mustela nivalis* Ойн үен -*Mustela sibirica* Орог зуцаг- *Phodopus sungorus* Дааран атаахай- *Sorex caecutiens* Тавшгар атаахай -*Sorex vir* CL. Алцн Усны багвайхай -*Myotis mystacinus* Kuhl Сахалт багваахай -*Myotis daubenton* Kuhl Үлийн цагаан оготно -*Lasiopodomys brandti* Rad Бор туулай- *Lepus tolai* Мэхээрч оготно- *Microtus oeconomus* Хэргэлзийн оготно-*M. gregalis* Гэрийн хулгана- *Mus musculus* Солонго- *Mustela altaica* Дорго-*Meles meles* Хөх шишүүхэй- *Cricetulus barabensis* Өмхий хүрнэ- *Mustela eversmanni* Цармын атаахай- *Sorex tundrensis* Чандага-*Lepus timidus* Хэрэм-*Sciurus vulgaris* Жирх- *Tamias sibirica* Олби- *Pteromus volans* Ойн улаан оготно-*Clethrionomys rutilus* Ойн хүрэн оготно- *Clethrionomys rufocanus* Ойн хөвхөлжин- *Myopus schisticolor* Шилүүс- *Lunx lunx* Зэрлэг гахай- *Sus scrofa* Хүдэр- *Moschus moschiferus* Халиун буга- *Cervus elaphus* Бор гөрөөс- *Capreolus pygargus* зэрэг амьтдаас гадна гэрийн тэжээвэр амьтад болох таван хошуу мал багтана.

2.7 Түүх соёл

Төв аймаг Сэргэлэн сум. Манзушири хутагтын хийд Хуучин Богдын их шавийн нутаг одоогийн Төв аймгийн Зуун мод сумаас хойш 8 км газар Богд хан уулын өмнөд ингэрт энэхүү хийдийг 1750 онд анхдугаар Манзушир хутагт Агваанжамбалданзан гэгч 13 тангад ламтай ирж газар шинжэж явтал цагаан чулуугаар маш уран сийлсэн нэг цагаан өвгөн, 15 Найдан бурхан газар доор булаатай байсан нь гарсан учир бэлэг учрал хэмээн энд хийдээ байгуулж дашчойнхорлин буюу “Өлзийт номын хүрд эргүүлэгч хийд” хэмээн нэр авчээ. Харин уг хийдийн үүсэн байгуулагдсан нөхцөл шалтгаан он цагийн тухай дараах түүхийн баримтууд эдүгээ бидний үед хадгалагдан ирсэн байна. Үүнд “...Харьяат шавийн аймаг савыг баригч Ачит Номун хан Донхор хутагтын арванхоёрдугаар үеийн хувилгаан Лувсанжамбалданзан Чин улсын Энх Амгалангийн гучиндөрөвдүгээр /1695/ онд Хөх нуурын газраа хувилгаан гарч Халхын газраа ирээд тэр цагт Жибзундамба хутагтад багш болсны учирт Тэнгэрийн Тэтгэсний дөрөвдүгээр /1739/ онд хаан сайшааж Аймаг савыг баригч ячит номун хан цол, тамга, жуух шагнан өгчээ.

2.8 Нийгэм эдийн засаг

Төв аймгийн Сэргэлэн сум нь 1924 онд байгуулагдсан, хуучнаар Түшээт хан аймгийн Дархан гүний хошуу. Баян бүрд, Хайрхан, Хөшиг, Эрдэнэ-Уул, Авдар гэсэн 5 багийн нийт 768 өрхөд 2146 хүн амьдардаг.

Хүн амын тоогоор Төв аймгийн 26 сумаас 16-д, газар нутгийн хэмжээгээр эхний 5-д ордог. Төв аймгийн зүүн урд хэсэгт, Улаанбаатар хотоос 62 км, аймгийн төвөөс 15 км зайд байрладаг. Улаанбаатар хот болон Төв аймгийн Алтанбулаг, Эрдэнэ, Баян, Баянцагаан сумтай хиллэдэг. Газар нутаг Нийт газар нутгийн хэмжээ 3865,7 га.



2.8.1 Хөдөлмөр эрхлэлт

Хүснэгт 3. Сэргэлэн сумын газар нутгын хэмжээ

Зориулалт	Хэмжээ /га/	Нийт талбайд эзлэх хувь
Хөдөө аж ахуйн газар	36446,75	91.8
Ойн сан бүхий газар	4975,80	1.27
Усан сан бүхий газар	309	0.08
Тусгай хэрэгцээний газар	18201.8	4.71
Тосгон, суурингийн газар	5172.76	1.25
Дэд бүтцийн газар	3448.9	0.89

2.8.2 Хүн ам

Хүснэгт 4. Хүн ам, өрхийн тоо

Үзүүлэлт	Сумын төвд	Хөдөөд	Нийт
Хүн амын тоо	550	1596	2146
Өрхийн тоо	187	581	768
Суурин хүн ам	2146		
Түр оршин суугч	000		

2.8.3 Хүн ам нас, хүйсээр

Хүснэгт 5. Хүн ам, хүйс

Насны бүлэг	Нас	Нийт	Хүн амын тоо	
			Эрэгтэй	Эмэгтэй
нийт (0-4)		201	108	93
нийт (5-9)		211	100	111
нийт (10-14)		209	118	91
нийт (15-19)		130	76	54
нийт (20-24)		134	65	69
нийт (25-29)		130	87	43
нийт (30-34)		166	102	64
нийт (35-39)		181	105	76
нийт (40-44)		165	88	77
нийт (45-49)		148	89	59
нийт (50-54)		117	69	48

нийт (55-59)	113	59	54
нийт (60-64)	113	52	61
нийт (65-69)	62	31	31
нийт (70-74)	26	12	14
нийт (75-79)	13	3	10
нийт (80-84)	15	7	8
нийт (85-89)	9	3	6
нийт (90-94)	2		2
нийт (95-99)	1	1	
Бүгд	2,146	1,175	971

2.8.4 Эдийн засаг

Сумын хэмжээнд нийт 155 аж ахуйн нэгж байгууллага бүртгэлтэйгээс 60 АН тогтмол үйл ажиллагаа явуулж улсад 90.5, сая, аймагт 1748.9 сая, орон нутагт 8337.9 сая нийт 10176.3 сая төгрөгийн татвар төвлөрүүлж байна.

Тус суманд улсын хэмжээний томоохон төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа нь орон нутгийн болоод улс орны эдийн засаг хөгжилд ихээхэн нөлөө үзүүлхүйц байгууламжууд хийгдэж байна.

Үүнд: 50квт салхин цахилгаан станц 2013онд ашиглалтанд орон үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байна..

Олон улсын нисэх онгоцны буудал 2021 онд, Жилд 100 сая тонн цемент үйлдвэрлэх хүчин чадал бүхий цементийн үйлдвэр мөн хийт бетон үйлдвэрүүд 2015 онд ашиглалтанд орж улсынхаа нүүр царай болсон төслүүд хэрэгжиж байна.

Хүснэгт 6. Ажиллах хүч салбараар

Салбар	Хэмжих нэгж	2022		
		Сумын төвд	Хөдөөд	Нийт
Аж үйлдвэр	Хүн	15	43	58
Хөдөө аж ахуй	Хүн		757	400
Төрийн байгууллага	Хүн	106	0	106
Нийт	Хүн	121	800	921

2.8.5 Боловсрол

Ерөнхий боловсролын 9 жилийн сургуулийн 9 бүлэгт өдрөөр суралцаж, албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр бага, суурь, бүрэн бус дунд боловсрол олгож байна. Бага ангийн хамран сургалт 46 хувь, суурь боловсролын хамран сургалт 48 хувьд хүрсэн. Ерөнхий боловсролын сургуульд мэргэжилтэй багшийн хангалт 100% хувьтай байгаа ба мэргэжил дээшлүүлэх хөрвөх сургалтанд нийт 14 багш хамрагдаж байна.

2.8.6 Эрүүл мэнд

Суманд улсын төсвийн 10 ортой 1 эмнэлэг, 1 эмийн сан үйл ажиллагаа явуулж, 2 их эмч, 10 эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд ажиллаж байна.

2022 онд нийт 16 хүүхэд мэндэлж, 0-1 насны хүүхдийн эндэгдэл, эхийн эндэгдэл байхгүй байна. Нийт өвчлөлийг авч үзвэл халдварт бус өвчлөл 488, осол гэмтэл 5, халдварт өвчлөлийн 101 тохиолдол гарсан байна.



БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү бүлэгт төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд түүнд өртөх газрын гадарга агаар, гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг, түүх соёлын дурсгал, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тодорхой тусгана.

Уг төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд учирч болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, дүгнэлт, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм, эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, судалгаа явуулсан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн тодорхойлов. Тус төслийн үйл ажиллагаанаас сөрөг нөлөөлөлд өртөгдөх байгалийн үндсэн тусагдахуун нь агаар, хөрс, ус, газрын гадарга, ургамал юм.

3.1 Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

- Химийн бодисын хадгалалтын явцад тухайн бодисын хор аюулын лавлах мэдээлэл болон химийн бодис хадгалах шаардлагын дагуу хадгалаагүй, хамт хадгалах хориотой бодисын хамт хадгалсан тохиолдолд химийн бодис асгарах, алдагдах зэргээр агуулахын дотоод орчны агаарын чанарт сөргөөр нөлөөлөл үүснэ.
- Химийн бодисыг хадгалалтын горим хангахгүй нөхцөлд хадгалбал халснаас ууршиж дотоод даралт нэмэгдэх, дулаанд тогтворгүй бүтээгдэхүүн үүсэх, нарны гэрэл болон хэт ягаан туяанаас исэлдэх, полимержих зэргээр бүтээгдэхүүний шинж чанар өөрчлөгдөж, тэсэрч дэлбэрэх, галын аюул гарах, бүтээгдэхүүний чанар өөрчлөгдөх, асгарч алдагдах эрсдэлтэй
- Химийн бодис тээвэрлэх машины тоног төхөөрөмж, ялангуяа дизель түлшээр ажилладаг хүнд даацын машин, техникийн хорт утаа ялгарах зэргээр агаарын чанарт сөргөөр нөлөөлнө.
- Химийн хорт болон аюултай бодисыг тээвэрлэх шаардлагыг дагаж мөрдөөгүй, химийн бодисын хор аюулын лавлах мэдээлэлд заасны дагуу тээвэрлээгүйн улмаас тээвэрлэлтийн үед ачаа унах, сав баглаа боодол гэмтэх, холилдох зэргээр химийн бодис алдагдах, химийн бодисууд урвалд орох, галын аюул гарах зэргээр агаарын чанарт сөргөөр нөлөөлнө.

3.2 Усны нөөц, чанарт гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж

- Химийн бодисын хадгалалтын явцад тухайн бодисын хор аюулын лавлах мэдээлэл болон химийн бодис хадгалах шаардлагын дагуу хадгалаагүй, хамт хадгалах хориотой бодисын хамт хадгалсан тохиолдолд химийн бодис асгарах, алдагдах зэргээр агуулахын дотоод орчны усан орчинд сөргөөр нөлөөлнө.
- Химийн бодисыг хадгалалтын горим хангахгүй нөхцөлд хадгалбал хэт хөрснөөс талсжих, халснаас ууршиж дотоод даралт нэмэгдэх, дулаанд тогтворгүй бүтээгдэхүүн үүсэх, нарны гэрэл болон хэт ягаан туяанаас исэлдэх, полимержих зэргээр бүтээгдэхүүний шинж чанар өөрчлөгдөж, тэсэрч дэлбэрэх, галын аюул гарах, бүтээгдэхүүний чанар өөрчлөгдөх, асгарч алдагдах эрсдэлтэй.
- Химийн бодис тээвэрлэх /машины тоног төхөөрөмж, ялангуяа химийн бодис ил задгай сав баглаа боодол эвдэрч гэмтсэн/ үед цас борооны усаар угаагдан норж машины тэвш, газарт химийн бодис үлдэх зэргээр хөрс, гадаргын болон гүний усны чанарт сөргөөр нөлөөлнө. Гэхдээ энэ нь түр зуурын тархмал шинж чанартай байна.



- Химийн хорт болон аюултай бодисыг тээвэрлэх үед ачаа унах, сав баглаа боодол гэмтэх, холилдох зэргээр химийн бодис алдагдах, химийн бодисууд урвалд орох, газрын гадарга болон доорх усны чанарт сөргөөр нөлөөлнө.

3.3 Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

- Химийн бодисын хадгалалтын явцад тухайн бодисын Хор аюулын лавлах мэдээлэл болон химийн бодис хадгалах шаардлагын дагуу хадгалаагүй, хамт хадгалах хориотой бодисын хамт хадгалсан тохиолдолд химийн бодис асгарах, алдагдах зэргээр агуулахын дотоод орчны хөрсний чанарт сөргөөр нөлөөлнө.
- Химийн бодис тээвэрлэх /машины тоног төхөөрөмж, ялангуяа химийн бодисыг ил задгай тээвэрлэх, сав баглаа боодол нь эвдэрч гэмтсэн/ үед цас борооны усаар угаагдан норж машины тэвш, газарт химийн бодис үлдэх зэргээр хөрсний чанарт сөргөөр нөлөөлнө. Гэхдээ энэ нь түр зуурын тархмал шинж чанартай байна.
- Химийн бодисыг тээвэрлэх ба тээвэрлэлтийн явцад тоосжилт үүсэх, Хамгаалалтын сахиул айл, агуулахын байр талбай, машин техник, хүнд механизмуудын зогсоол зэрэг газарт хөрс ургамал талхлагдах, шатах тослох материал, хог хаягдлаар орчин, хөрс бохирдоно.
- Агуулахын ажилчдын байр, машин техник, хүнд механизмуудын зогсоол зэрэг газарт хөрс ургамал талхлагдах, шатах тослох материал, хог хаягдлаар орчин, хөрс бохирдоно.
- Химийн бодисыг ачиж, буулгах үед аюулгүй ажилгааны дүрмийг баримтлаагүйн улмаас хөрсөн дээр асгарах, хөрсөн бүрхэвч бохирдох

3.4 Ургамлын аймаг, ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

- Ургамлын бичил орчин өөрчлөгдсөнөөс нутгийн унаган ургамалшилтад өөрчлөлт орж, хогийн ургамлын төрөл зүйл ихсэх магадлалтай.
- Агуулахын үйл ажиллагаа, автомашины замын тоос зэрэг нь ойр орчмын агаарыг тоосжуулахаас гадна, ургамлын навч эрхтэнд шороон тоос цугларч ойр хавийн ургамлын цаашдын амьдралд сөрөг нөлөө үзүүлнэ.
- Ургамлын ургац ашиглалт явуулж буй хэсэгт бүрмөсөн устаж, зарим халцгай буюу талхагдаж орсон хэсэгт хогийн ургамал ялангуяа шарилж ихээр ургаж хүн амьтны амьсгалд тоосны аллерги үүсэх үндэстэй
- Машин техник хэрэгслийн түлш шаталтын дүнд үүссэн хорт хийд агуулагдаж буй NOx болон SOx тунадастай хамт юмуу хатуу тоос хэлбэрээр ургамлан бүрхэвч дээр бууж цааш хөрсөөр дамжин тархан ургамал, амьтанд сөргөөр нөлөөлөх.

3.5 Амьтны аймагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах арга хэмжээний зөвлөмж

- Химийн бодис тээвэрлэх, ажилчид ажилдаа явах үед машинд дайрагдах, дуу шуугиан, тоос шорооны улмаас ихэнх хөхтөн амьтад дайжин үргэх зэргээр нөлөөлнө.
- Хүнд, машин техникийн дуу чимээ, хөдөлгөөн, янз бүрийн таагүй үнэр, гэрэл эрс нэмэгдэж тухайн нутаг болон орчны бүс дэхь амьтдын тайван байдал алдагдаж, дүрвэн зайлж байршил нутгаа өөрчлөнө.
- Тоосжилтоос орчны бэлчээрийг бохирдуулж мал болон өвсөн тэжээлт амьтдыг ямар нэг хэмжээгээр хордуулна. Машин техник олшрох тутам орчны хөрсний элэгдэл эвдрэл, бэлчээрийн талхигдал ихсэж амьтад амьдрах боломжгүй болно.



- Техникийн тос, шатахуун, янз бүрийн хаягдалд амьтад хордож үхэх, тэдгээрийг идсэн махчин амьтад хордоно. Хөрсний бичил биетэн, шавж олноор устаж үгүй болно.

3.6 Хүний эрүүл мэнд болон аюулгүй ажиллагааны үед үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

- Химийн бодисыг хор аюулын лавлах мэдээлэлд заасны дагуу болон стандартын дагуу хадгалаагүй улмаас тэсэрч, дэлбэрэх, урвалд орох, галын аюул гарснаар ажилчдын эрүүл мэнд болон үйлдвэрийн эд хогшил, байгаль орчинд сөрөг нөлөөллийг үзүүлнэ
- Химийн бодисыг тээвэрлэн авчрахад хурд хэтрүүлэх, хөдөлмөр аюулгүй байдлын дүрмийг даган мөрдөж ажиллаагүйн улмаас осол аваар гарах, хүний амь нас эрсдэх эрсдэлтэй
- Хүний буруутай үйл ажиллагааны улмаас галын аюул гарах, осол аваар гарах, ХАБ дүрмийг даган мөрдөөгүй зэргээр хүний амь нас болон үйлдвэрийн эд хогшилд сөрөг нөлөөллийг үзүүлэх эрсдэлтэй
- Агуулахын ХАБ-ын дүрэм зорчих зэргээс үүдэн ажилчдын эрүүл мэнд аюулгүй байдалд эрсдэл учруулна.

3.7 Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

- Байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл (газар хөдлөлт, үер, хүчтэй салхи, хүчтэй шуурга) болоход гэмтэж бэртэхээс урьдчилан сэргийлж, ажиллагсдыг сургалтад хамруулж дадлагажуулах, эмнэлгийн анхны тусламжийн хайрцгийг талбайд байрлуулах.
- Ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохыг хатуу хориглох.
- Ажиллагсдад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар мэдлэг олгох сургалтыг зохион байгуулах.
- Ажил олгогч нь ажилтнуудын ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах.

3.8 Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөмж

- Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл нь дам байдлаар хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болно. Иймд ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөл үүсэхээс сэргийлж агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг дагаж мөрдөх.
- Ажилтан бүр ажил олгогчийн баталсан жагсаалтын дагуу хөдөлмөрийн нөхцөл, ажил, үүргийн онцлог тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангагдаж, тэдгээрийг хэрэглэх үүрэгтэй.
- Ажилтнууд өөрсдийн ажлын байранд холбогдох хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааврыг удирдлага болгоно.
- Ажлын байрны аюулгүй ажиллагааны нөхцөлд байнга хяналт тавьж, осол аюул гарсан тохиолдолд шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр бүрэн хангах, холбогдох сургалтыг явуулах.
- Ажлын байрны эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөл болон тохижилтыг дээд зэргээр ханган, байнгын хяналт тавин ажиллах.
- Ажиллагсдыг ажилд ороход нь эмнэлгийн үзлэг хийлгэж, эрүүл мэндийн хувьд тэнцэх эсэхийг тодорхойлуулсан байх ба эрүүл мэндийн үзлэгт жилд 1 удаа хамруулахын зэрэгцээ эрүүлжүүлэх арга хэмжээ зохион байгуулах.



БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Химийн бодисын агуулах” төслийн БОМТ-г Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав. БОМТ-ний хүрээнд авч хэрэгжүүлэхэд 7.55.000 зарцуулахаар байна.

Хүснэгт 7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн дүн

№	Зардлын ангилал	2025 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж	1.700.000
2	Орчны тохижилт нөхөн сэргээлтийн зардал	500.000
3	Хог хаягдал	360.000
4	Удирдлага зохион байгуулалт	-
5	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	4.600.000
6	ОХШХ	395.000
7	БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хэлэлцүүлэх хуваарь	-
Нийт дүн		7.555.000



БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Химийн бодисын агуулах” -ний төслийн Байгаль орчны ерөнхий үнэлгээний тогтоогдсон төслийн гол ба болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийн хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг тодорхойлон нэгтгэж тусгалаа.

Хүснэгт 8. Төслийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө								
Агуулахын агааржуулалтын ажиллагаа болон агуулахын агаарт тавигдах стандарт горим алдагдсанаас бодис уурших, халах, тэлэх нөхцөл үүснэ.	Химийн боисын агуулахад агааржуулах төхөөрөмжийг суурилуулан тогтмол ажиллуулах	Агуулахын дотоод орчинд	төг	200.000	4 ш	800.000	2025 он	MNS 6458:2014 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах, 5.11 Агааржуулалт
	Агааржуулалтын системийг шалгаж бүрэн бүтэн байдлыг хангах, тодорхой графикийн дагуу засвар үйлчилгээ хийх	Төслийн талбайг бүрэн хамрах	тогтмол	Үйл ажиллагааны хүрээнд			2025 он	MNS 5078 : 2001 Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Үйлдвэрийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага
	Химийн бодис материалын хадгалалтын нөхцлийн стандартыг нарийн баримталж уурших, халах, тэлэх нөхцлөөс бүрэн сэргийлж ажиллах	Химийн бодисын хадгалалт, тээвэрлэлт, ачилт буулгалт	төг	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах			2025 он	



**“ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК-ИЙН ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Химийн бодисуудын түүхий эдүүдийг тээвэрлэн ирж буулгах, бэлэн болсон бүтээгдэхүүнийг ачиж явах үед тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас гарах хорт хий агаар орчныг бохирдуулна	Химийн бодисын тээвэрлэлт хийх техникүүдийг жил бүр үзлэгт хамруулах Тоос, шороо сорох фильтрийн тоног төхөөрөмжийг судалж, сонгон авах, Агаар дахь хорт бодисын хэмжээг ЗДХ-нээс хэтрүүлэхгүй байх, ажлын байрны агаарын температур гэрэлтүүлэг, чийгийн хэмжээг хянаж, стандартад заасан хэмжээнд байлгах		тогтмол	Үйл ажиллагааны хүрээнд	2025 он	MNS 4585 : 2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 5011 : 2020 Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх заавар. Ерөнхий шаардлага
Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө						
Шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, ахуйн хог хаягдлаар хөрс бохирдох	Хөрсний бохирдлоос хамгаалах зорилгоор бүх ажилчдад техникийн болон ахуйн хэрэглээний аюултай материал (химийн бодис, шатамхай хий, шатах, тослох материал)-тай харьцах асуудлаар цогц сургалт, зааварчилгаа явуулах	Машин техник	тогтмол	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж оруулав.	2025 он	MNS3297-1991, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм”
	Хатуу хог хаягдлыг цуглуулж, зохих журмын дагуу зайлуулж байх	Үүсэх хог хаягдал	Тухай бүрд	Үйл ажиллагааны хүрээнд	2025 он	UCS 1701A:2022 “Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент” хотын стандарт
	Зориулалтын хог хаях цэгээс бусад газар хог хаягдал хаяхгүй байх, хог хаягдлыг ангилан ялгах арга хэмжээг хэвшүүлэх талаар ажилчдад заавар зөвлөгөө өгөх	Төслийн талбайд	Тухай бүрд		2025 он	



**“ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК-ИЙН ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	сургалт зохион байгуулах, самбар пайз байрлуулах						
Хөрсний үржил шимт давхаргыг хуулах хөрсний үржил шимт байдал алдагдах	Төслийн ногоон байгууламж байгуулах, мөн бүтээн байгуулалтын ажил хийхдээ өнгөн хөрсийг “Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт MNS 5916:2008”-д заасны дагуу хөрсний ялзмагт давхаргаас хамаарч хөрсийг хуулж, тусад нь хадгалах	Хөрсөн бүрхэвч	Тогтмол	Үйл ажиллагааны хүрээнд			MNS 5916:2008 “Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт
Асгаралтын иж бүрдэл ашиглах	Шатах тослох материал асгарсан тохиолдолд асгаралтын иж бүрдэл байршуулах	Агуулахын хэсэгт	2ш	200.000	400.000	2025 он	MNS ISO22320:2020
Химийн бодисын асгаралтын улмаас хөрсөн бүрхэвч бохирдох, хөрсний микроорганизм д нөлөөлөх	Бодисыг их хэмжээгээр асгарахаас болгоомжилж үргэлжийн хянуур ажиллах Асгарсан тохиолдолд ХАЛМ (MSDS)-д заасны дагуу яаралтай арга хэмжээ авах Хүнсний сод, элс, шороо, вермикулитыг ажлын талбарт бэлэн байлгах	Төслийн эхний жилд хийгдэх ажилд төлөвлөж оруулах	тогтмол	Үйл ажиллагааны хүрээнд			
	Химийн бодисын сав уутыг хадгалах түр цэгийг байгуулан хадгалах	Төслийн талбайд нэмэлтээр	1ш	500.000	500.000	2025 он	
Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ							
Бохирдлын эх үүсвэр шатах тослох материал,	Тослох шатах материалыг хадгалах, тээвэрлэх, ашиглах аюулгүй ажиллагааны журам боловсруулж хэрэгжүүлэх.	Төслийн хэрэгжиж буй замын хэсэгт	тогтмол	Үйл ажиллагааны хүрээнд			MNS 4586: 1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага



**“ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК-ИЙН ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

ахуйн бохир ус болно. гадаргын болон газрын доорх усыг шууд, шууд бусаар бохирдуулах	Зам талбайн усалгаа, ногоон байгууламжын усалгаанд гүний усны эх үүсвэрийг ашиглахгүй байх, саарал ус ашиглах	Зам талбай болон ногоон байгууламжийн усалгаа	тогтмол	Үйл ажиллагааны хүрээнд	“Усны тухай хууль” Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль
	Борооны ус хуримтлуулан дахин ашиглах зөвлөмж	Ус хэмнэх	тогтмол	Үйл ажиллагааны хүрээнд	
Химийн бодисын хадгалалтын явцад гүний усны эх үүсвэр бохирдох	Химийн бодисын хадгалалт тээвэрлэлтэд болон шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний бохирдол үүсгэхээс зайлсхийх	Төслийн талбайн гүний усруу нэвчихээс сэргийлэх	тогтмол	Үйл ажиллагааны хүрээнд	Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам
	Ус хангамжийн эх үүсвэрээс 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүс, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтоож мөрдөж ажиллах	Төслийн талбай	тогтмол	Үйл ажиллагааны хүрээнд	
Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө					
Химийн бодисын хадгалалт, тээвэрлэлтээс үүсэх, тоосжилтоос шалтгаалан төслийн талбайн ургамал нөмрөг доройтох	Орчны ургамлан бүрхэвч усах, талхлагдах, олон салаа зам гарахаас сэргийлэх, чөлөөт зорилтыг хязгаарлах арга хэмжээ авах	Төслийн талбай доторх	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд тусгасан болно.	2025 он	Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага. - MNS 5918:2023; Цэцэрлэг зүлэг ногоон байгууламж
	Замын хажуу хэсгийн ургамлыг аль болох сүйтгэхгүй байх. Машин техник тоног төхөөрөмж зөвхөн төлөвлөсөн замын дагуу явах	Төслийн талбайн хэсэгт	Үйл ажиллагааны хүрээнд	2025 он	



“ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК-ИЙН ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ					
Жижиг амьтдын үүр оромж	Газар шорооны ажлын үед жижиг амьтны үүр оромж хөндөгдөж эвдэгдсэн цэгүүдэд нөхөн сэргээлт хийх	Төслийн талбай	Үйл ажиллагааны хүрээнд	2025 он	Амьтны тухай хууль
Мал амьтад ухсан нүхэнд унаж бэртэх	Чулуу, элс хайрганы карьерын нурулт гулсалт үүсэж болзошгүй эгц налуу хэсгүүдэд хүн, мал амьтан орохоос хамгаалах хамгаалалтын хайс, тор хийх;	Төслийн талбай	Үйл ажиллагааны хүрээнд	2025 он	
Нийт дүн: 1.700.000					

БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 9.Төслийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Төслийн талбайн хашаалалтын дагуу мод, бут тарих	Шар хуайс	Хашааны дагуу -хуайс	ш	50	10000	500.000	2025 он	Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага. - MNS 5918:2023;
Нийт дүн: 500.000								

БҮЛЭГ 7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 10.Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө



**“ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК-ИЙН ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Байгалийн гаралтай, осол эрсдэл	Байгалийн гаралтай осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах	Нийт ажилчдад	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах дотоод зардалаар				MNS 4990: 2015 “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага”; MNS ISO 13688:2000, “ХААЭА. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага”;
	Гал гарах зэрэг онцгой нөхцөлд хариу ажиллах бэлэн байдал (журам мөрдөх, ажилчдыг сургах, тоног төхөөрөмж, хэрэгсэл, хангамж),	Төслийн талбайд бэлэн байдалд байлгах	1	500.000	500.000	2025 он	
Технологийн гаралтай осол эрсдэл	Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн ханган ажиллуулах	Бүх ажилчдад	2.500.000			2025 он	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Сургалтын хөтөлбөр
	Үйл ажиллагааны горим алдагдах, тоног төхөөрөмж эвдрэх, бие эрхтнээ гэмтээх, эрүүл мэндээр хохирох эрсдэл учирч болзошгүй тул эрсдэлээс хамгаалах арга хэмжээг нарийвчилж боловсруулах, эрсдэлийн санг бий болгох	Бүх ажилчдад	Жилд 1 удаа	1.000.000	1.000.000	2025 он	
	Осол эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авч ослын үед ажиллах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх бэлэн байдлыг хангах	Бүх ажилчдад	Осол эрсдэлийн төлөвлөгөө боловсруулж нийт ажилчдад танилцуулж ажилд гарахад наряд өгч гарах			2025 он	
Химийн бодисын тээвэрлэлтийн явцад үүсэж болзошгүй эрсдэл	Химийн бодисыг тээвэрлэх зориулалтын авто тээврийн хэрэгслийг тоноглох, Химийн бодис тээвэрлэх зам маршрутыг тодорхой болгон, тээвэрлэлт явуулах үйл ажиллагааг хянах, Химийн бодис тээвэрлэх үед химийн бодис алдагдахад авах арга хэмжээг төлөвлөх, хоргүйжүүлэх	Бүх ажилчдад	6 машин	100.000	600.000	2025 он	БОАЖЯ-ын Сайд, ЭМ-ийн Сайд, ОБЕГ-ын Даргын 2009 оны 02 сарын 03-ны өдрийн 28/40/29 тоот хамтарсан тушаалаар баталсан "Химийн



**“ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК-ИЙН ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	зааварчилгааг холбогдох хүмүүст өгч ажиллах					хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам” “Хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах, цуглуулах, тээвэрлэх, устгах” журам
Химийн бодисын хадгалалт, ашиглалт	ХБ-ын агуулах дотор болон агуулахын гадаад орчныг гэрэлтэй болгох, тэмдэгжүүлэх	Химийн бодисын агуулахын дотор талбайг	Дотоод зардалд зайлшгүй төлөвлөн тусгах			2025 он
Нийт дүн: 4.600.000						

БҮЛЭГ 8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 11. Түүх соёл өвийг хамгаалах төлөвлөгөө

Нөлөөлөлд өртөх түүх соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Төслийн үйл ажиллагаагаар түүх соёлын өвд үзүүлэх шууд сөрөг нөлөө байхгүй ч болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай.	Соёлын өвийг хамгаалах тухай МУ-ын хууль	2025 он	Бүтээн байгуулалтын үйл ажиллагааны явцад			Тухайн үед нь шийдвэрлэх	Соёлын өвийг хамгаалах тухай хууль

БҮЛЭГ 9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бид 2025 оны БОМТ-ний хүрээнд төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдал, хэрэгжүүлэх арга хэмжээ, хэрэглээний норм, гэх зэрэг үзүүлэлтүүдэд үндэслэн дараах байдлаар тооцлоо.

Хүснэгт 12. Төслийн хог хаягдлын төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ахуйн хог хаягдлыг тогтмол	Хог хаягдлын менежментийг зохистой төлөвлөн үйл ажиллагаандаа	Төслийн талбайн хог	тогтмол	Үйл ажиллагааны хүрээнд			2025 он	MNS3297-1991, “Байгаль хамгаалал.



**“ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК-ИЙН ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

зайлуулаагүйгээс орчин бохирдох	хэрэгжүүлэх буюу 3R зарчмыг баримтлан ажиллах	хаягдлын эх үүсвэр						Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм”
	Хатуу шингэн хог хаягдлыг графикийн дагуу орон нутгаас тогтоосон зөвшөөрөл бүхий нэгдсэн хогийн цэг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулж зайлуулах	Төслийн талбайгаас үүсэх хог хаягдал	төг	30.000	12	360.000	2025 он	
	Авто машин механизмын ашигласан тос, тосолгооны материалыг битүү саванд хуримтлуулан хадгалж дахин боловсруулах үйлдвэрт тушаах	Төслийн талбайн	тогтмол	Дотоод зардалаар тооцох			2025 он	Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7, 8.1.7а, 8.1.7.б, 8.1.7.г, 8.1.9, 8.1.9.а-д
	Талбайн цэвэрлэгээ хийх ба хог хаягдлыг зайлуулах явцад гүйцэтгэгч нь нийтийн болон хувийн өмчийг гэмтээхгүй ба замын хөдөлгөөнд саад учруулахгүй байх	Төслийн талбайн	тогтмол	Үйл ажиллагаа төслийн хүрээнд			2025 он	
Аюултай хог хаягдал	Химийн бодисын сав баглаа боодолоос үүсэх аюултай хог хаягдлыг өөрийн Химийн хуванцар сав баглаа боодол боловсруулах үйлдвэрт дахин боловсруулах	Төслийн талбайн	тогтмол	Үйл ажиллагааны хүрээнд			2025 он	
	Аюултай хог хаягдлыг хүлээн авч хуримтлуулж буй талбайг бүрэн цементжуулж хөрсний бохирдол үүсгэхгүй байх	Төслийн талбайн	тогтмол	Үйл ажиллагааны хүрээнд			2025 он	
	Буцаан татах химийн бодисын тоо хэмжээ	Төслийн талбайн	тогтмол	1400 тн хог хаягдлыг эргүүлэн татна. Дотоод төлөвлөлтөөр зардал тусгах			2025 он	
Нийт дүн: 360.000								



БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Төслийн үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” гэнэ. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр нь “Химийн бодисын агуулах” төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд гарч байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлох, болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилготой. Бид 2025 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа болон давтамжийг тусгалаа.

Хүснэгт 13. Төслийн орчны хяналт шинжилгээ хийх төлөвлөгөө

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал /төгрөг/	Нийт зардал, төг	Тайлбар	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ялгарах бохирдуулагчид: SO ₂ , CO, NO ₂	Төслийн талбайд 1 байршилд	Жилд 1 удаа буюу 10 саруудад дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө	2 удаа	55.000	110.000	Үйл ажиллагаа жигдэрсэн үед хийлгэх	2025 он	MNS 4585:2016,
Хөрсний өнгөн болон дээд үе давхаргын элсжилт, чулуужилт, тоосжилт зэрэг морфологи тогтцын өөрчлөлтийг хянах	Төслийн талбайд 1 байршилд	Төслийн талбайд	3 удаа	45.000	135.000	Үйл ажиллагаа жигдэрсэн үед хийлгэх	2025 он	MNS 5850:2019,
Гүний худгаас усны ерөнхий шинжилгээ хийлгэх	Төслийн талбайд 1 байршилд	Төслийн талбай	1 удаа	150.000	150.000	Жилд 1 удаа буюу 1 сард усны шинжилгээ хийлгэх	2025 он	MNS 1097:2023
Нийт дүн: 395.000								

БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 14. Төслийн удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө



**“ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК-ИЙН ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
		2025 он				
		Сар	Сар	Сар		
Ажилчдад аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол зохион байгуулж байх;	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	Улирал бүр			"Цэцүүх Трейд" ХХК гүйцэтгэх захирал Н.Билгүүн	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, Үйлдвэрлэлийн эрүүл ахуй” MNS ISO 13688: 2000
Ажиллагсадыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах;	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	Жилд 1 удаа			"Цэцүүх Трейд" ХХК гүйцэтгэх захирал Н.Билгүүн	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын тусгай хувцас- Ерөнхий шаардлага
Тухайн жилийн БОМТөлөвлөгөөг батлагдсан журмын дагуу жил бүр боловсруулан батлуулах;	Дотоод төлөвлөлтөөр	2025 он			"Цэцүүх Трейд" ХХК гүйцэтгэх захирал Н.Билгүүн	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Мэргэжлийн байгууллагатай хамтран хог хаягдлын талаар жилд 1 удаа сургалт зохион байгуулах /аюултай хог хаягдлын талаар/	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	2025 он			"Цэцүүх Трейд" ХХК гүйцэтгэх захирал Н.Билгүүн	Хог хаягдлын тухай хууль

БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 15. Төслийн нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
Химийн бодисын агуулах төслийг БОМТ	Цаасан хэлбэрээр	Төлөвлөгөөт Ажлын тайлан,	Жил бүрийн 10 дугаар сард	Дотоод төлөвлөлтөөр	"Цэцүүх Трейд" ХХК гүйцэтгэх	"Цэцүүх Трейд" ХХК



**“ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК-ИЙН ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

БОХ-ыг таниулах, мэдээлэх, тус багийн оршин суугчдад таниулах		Биелэлтийн үр дүн, Дараа жилийн БОМТ			захирал Н.Билгүүн	
Химийн бодисын агуулах төслийг харьяаллын багын ИНХ,	Мэдээллийн илтгэл, хэвлэмэл танилцуулга	Төлөвлөгөөт Ажлын тайлан, Биелэлтийн үр дүн, Дараа жилийн БОМТ	Жил бүрийн 10 сарын 15-ны дотор	Дотоод төлөвлөлтөөр	"Цэцүүх Трейд" ХХК гүйцэтгэх захирал Н.Билгүүн	Багын ИНХ-н танхимд